

БАТЛАВ
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
 ЯАМНЫ ТӨРИЙН БАРИЙН
 БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
 УДИРЛАГЫН ГАЗРЫН
 ДАРГА ЦОДХҮҮ

"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫГ ДАГАСАН НИСЭХ БУУДЛЫН ЗОРЧИГЧ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
 БАРИЛГА БОЛОН БУСАД ИНЖЕНЕРИНГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖУУДЫН ИЖ
 БҮРЭН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05-р сарын 01-ны өдөр

Дугаар: 11.....

Д/д	Тайлбар	Ерөнхий шаардлага
1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг "Хархорум хотыг сэргээн байгуулах тухай"; - Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол "Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай"; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" батлах тухай; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлах тухай; - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоол, "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо байгуулах тухай; - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 21 дүгээр тогтоол, "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай"; - Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хорооны даргын баталсан "Шинэ Хархорум" хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2025); - Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаал.
2	Нэр, байршил	- Архангай аймаг, Өгийнуур сум.
3	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"> - Зам, тээврийн хөгжлийн яам; - Иргэний нисэхийн ерөнхий газар.
4	Зургийн ажлыг гүйцэтгэх Зөвлөх	- Нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, төхжилт, өндөржилт, барилгын бүтээц, дэд бүтэц болон

Бүртгэлийн дугаар 213
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон ажилтны сарын үсэг
 2024 оны 05 сарын 06-ны өдөр

		<p>тэдгээрийн инженерийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага.</p> <ul style="list-style-type: none"> - Онцгой төвөгшилтэй барилга байгууламжын зураг боловсруулж байсан байх. - Нисэх буудлын зураг төсөл гүйцэтгэж, хэрэгжүүлсэн байх.
5	Зураг төслийн үе шат, хугацаа	- 1 үе шаттай ажлын зураг, төсөв, 2024 он.
6	Аэродромын хяналтын код	- 4E /ИКАО-ын баримт бичиг, хавсралтууд/
Нэг. Барилга байгууламж		
1.1	Ерөнхий шаардлага	- Нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолбор болон инженерингийн барилга байгууламж /Дулааны станц, цэвэрлэх байгууламж, цэвэр усны байгууламж г.м/-ийг бие даасан байдлаар шийдэх.
1.2	Барилга байгууламжийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Нисэх буудлын ерөнхий төлөвлөгөө боловсруулах M1:2000 - Зорчигч үйлчилгээний барилгын хүчин чадлыг тодорхойлж, зураг төслийг боловсруулах, - Нислэгийн хөдөлгөөний хяналтын цамхаг, - Захиргааны барилга, - Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга, - Гал унтраах авран хамгаалах албаны барилга, - Цэвэр усны байгууламжийн зураг төсөл, - Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, - Дулааны станцын барилга, гадна дулаан хангамж - Цахилгааны дэд өртөө, барилгын зураг төсөл, - Аэродромын үйлчилгээний барилга - Газрын үйлчилгээний гараашны барилгын зураг төсөл, - Техник технологийн болон үйл ажиллагааны зориулалт бүхий туслах барилгууд <ul style="list-style-type: none"> • Хяналтын цамхгийн цахилгааны дэд өртөө • Курсийн радио маякын цахилгааны дэд өртөө • Глиссадын радио маякын цахилгааны дэд өртөө • Курсын радио маякын байр • Глиссадын радио маякын байр • Хэт богино долгионы радио нэвтрүүлэх төв • Харуул хамгаалалтын байр • Генераторын байр • Хураамжийн цэг - "Шинэ Хархорум" хотыг дагасан нисэх буудлын үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламжууд нь дээрхээр хязгаарлагдахгүй бөгөөд зураг төсөл зохиогч байгууллага шаардлагатай тохиолдолд нэмэлтээр барилга байгууламжийг тусгаж болно. Барилга байгууламжууд нь байгаль орчинд ээлтэй эко, дижитал, смарт, орчин үеийн (Universal design буюу Түгээмэл загвар) шийдэлтэй байх.
1.3	Архитектур, орон зайн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Зорчигч үйлчилгээний барилгын гадна өнгө төрхийг бүс нутаг болон түүх дурсгалт, өв соёл шингэсэн байхаар төлөвлөх; - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалын дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох БНБД"-ийн төлөвлөх;



		<ul style="list-style-type: none"> - Гадна зам талбайн ерөнхий төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөх; - Зорчигч үйлчилгээний барилгад олон улс, орон нутгийн ирэх явах танхимуудыг төлөвлөх, бүртгэлийн хэсэг, мэдээллийн хэсэг, VIP зорчигчдод зориулсан шаардлагатай өрөө танхимууд, кофе шоп, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, эх хүүхдийн өрөө, аюулгүй байдлын хангах тусгай үзлэгийн өрөө, ачаа тээш конвейрийн системтэй, ачаа хадгалах газар, ачаа буулгах хэсэгт машин орох боломжтой байх, шуудан холбооны салбар, банк, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө, камерын хяналт, онцгой байдлын үед ажиллах зохицуулалтын өрөө, зорчигч зарлан мэдээлэх өрөө зэргийг төлөвлөх; - Зорчигчид зориулсан мэдээлэх тэмдэглэгээг олон улсын стандартын дагуу төлөвлөх; - Нислэг хөдөлгөөний хяналтын цамхаг, Гал унтраах авран хамгаалах алба, навигацийн тоног төхөөрөмжийн техникийн тасалгаа, аэродромын нэгж, байгууламжийг цогц барилгаар төлөвлөх; - Ерөнхий төлөвлөгөөг ИНЕГ-тай зөвшилцөх;
1.4	Барилгын хийц бүтээц, ашиглах материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтэц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох ба барилгын хүчин чадлыг өргөтгөх боломжтой хийц бүтээцээр төлөвлөх; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын шаардлага хангасан материал сонгох; - Барилга байгууламжуудыг эдийн засгийн хувьд үр ашигтай материалаар төлөвлөх; - Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан барилгын материалыг орчин үеийн техник-технологи байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй байдлаар сонгох ба барилгын хүчин чадлыг өргөтгөх боломжтой хийц бүтэц, БНБД-ийн дагуу төлөвлөх; - Агаарын хөлөгт гялбаа үүсэхгүй нөхцөлийг хангах; - Шатахууны агуулахыг MNS 4628:1998 "Шатахуун түгээх станц", MNS 5746:2007 "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг агуулах, технологийн байгууламжийн техникийн ерөнхий шаардлага"-ын дагуу төлөвлөх; - MNS 5309:2003 "Цилиндр, хэвтээ ган нөөцлөх сав. Шалгах арга хэрэгсэл"; - Барилгын зураг төсөл, бүтээцтэй уялдуулж гүйцэтгэх; - Инженер геологийн судалгааг үндэслэн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх.
1.5	Инженерийн хангамж, байгууламжийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай холбогдох баримт бичиг, техникийн нөхцөлүүдийг бүрдүүлэх; - Усан болон агаарын халаалтын системтэй, - Ердийн болон механик салхивч агааржуулалтын системтэй; - Дулааны эх үүсвэрийг бие даасан байгальд ээлтэй эко системтэйгээр шинээр, эсхүл "Шинэ Хархорум" хотын дэд бүтэцтэй уялдуулах байдлаар төлөвлөх; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна нөөц тэжээлтэй байх; - Интернэт шилэн кабелиар холбох, хяналтын камер, галын болон бусад шаардлагатай дохиолол, төлөвлөсөн байх;



		<ul style="list-style-type: none"> - Холбоо, цахилгаан хангамжийг орон нутгаас өгсөн техникийн нөхцөлүүдийн дагуу төлөвлөх бөгөөд техникийн зургийг ИНЕГ-тай зөвшилцөх; - Шинэ нисэх буудлын дэд бүтцийн асуудлыг "Шинэ Хархорум" хотын дэд бүтэцтэй уялдуулах байдлаар төлөвлөх.
1.6	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Олон улсын агаарын тээвэрлэгчийн холбоо /IATA/-ноос гаргасан нисэх буудлыг төлөвлөх гарын авлагын дагуу төлөвлөх; - Нислэг хөдөлгөөний хяналтын цамхаг /Air Traffic Control Tower Design & Construction олон улсын жишиг стандарт/ төлөвлөх; - Нисэх буудлын барилга байгууламжуудыг аэродромын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, - Газар хөдлөлтийн 9 балл; - Инженер геологи, геодезийн хайгуул, зураглалын ажлыг нисэх буудлын бүхийл барилга байгууламжууд болон бусад инженерингийн байгууламжуудын талбайд хийж гүйцэтгэх; - Олон улсын иргэний нисэхийн байгууллагын техникийн баримт бичиг болох Док 9137-ын 7-р дэвтэр буюу Онцгой байдлын үед ажиллах өрөө тасалгаа, мэдээллийн хэрэгсэл техник тоног төхөөрөмжүүдийн иж бүрэн төлөвлөх; - Аюулгүйн байдлын үзлэг шалгалтын тоног төхөөрөмж, тусгай үзлэг өрөөг Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын хавсралт 17-ын шаардлагын дагуу төлөвлөх; - Цахилгаан хангамжийн нөөц тэжээл байрлуулах; - Ердийн болон механик салхивч агааржуулалтын хосолсон системтэйгээр төлөвлөх; - Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдын тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг хангасан байх; - Аюултай ачаа болон үнэт ачаа, шуудангийн төлөвлөлтийг карго барилга дээр төлөвлөх; - Инженерингийн байгууламжуудыг өндрийн саадын тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох. /ЗТХ-ийн сайдын 2020 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан "Аэродром төлөвлөлт ба ашиглалт" Техникийн баримт бичгийн 4 болон 6 дугаар бүлгийн заалт/ дагуу төлөвлөх; - Нислэг хөдөлгөөний хяналтын цамхгийн барилга дахь навигацийн тоног төхөөрөмжийн техникийн ерөөний агаарын температур болон чийгшлийг тодорхой барьж байх систем төлөвлөх; - Эрчим хүчний хангалтыг 1 дүгээр зэрэглэл болон нөөц генератор байхаар төлөвлөх; - Барилга байгууламжуудаас гялбаа үүсэхгүй байхаар төлөвлөх.
1.7	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсад мөрдөгддөг норм дүрмүүдийг баримтлах; - Барилгын галын аюулгүй байдал БНБД 21-01-02; - Барилга байгууламжийн материалууд нь галд тэсвэртэй лабораториор баталгаажсан сертификаттай стандарт шаардлага хангасан байх; - Барилга байгууламжуудад ашиглах материал Галын БНБД-ийн шаардлагыг хангасан материалуудыг сонгож зурагт тусгах; - Галын дохиололтой байх;

Бүртгэлийн дугаар 213
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажлын үндсэн гарын үсэг
.....
2024 оны 08 сарын 08-ний өдөр

		<ul style="list-style-type: none"> - Галын гидрант, гал унтраах иж бүрэн системтэй байх; - Гал, ослын гарцыг саадгүйгээр төлөвлөх, орц гарцын схемтэй байх; - MNS 5282:2003 "Газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүй байдал"; - БНБД 21-03-04 "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм".
1.8	Гадна тохижилт	<ul style="list-style-type: none"> - Зам талбай, автомашины зогсоол, бут сөөг, зүлэг, ногоон байгууламж, цэцгийн мандал, сүүдрэвч, амралтын сандал, хог хаягдлыг төвлөрүүлэх талбай болон бусад тохижилт зэргийг иж бүрэн төлөвлөх; - Гадна талбайд түүх дурсгал, өв соёлын агуулга шингэсэн бэлэг тэмдэг байрлуулах талбайг төлөвлөх, ерөнхий загварыг боловсруулах.
1.9	Төслийн баримт бичиг	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан (зураг төсөл, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (5 хувь флаш-нд бичиж) бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг хүлээлгэж өгнө. <ul style="list-style-type: none"> • Тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls, AutoCAD өргөтгөлөөр, байр зүйд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгнө.


Танилцсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны
Иргэний нисэхийн бодлого
зохицуулалтын газрын ахлах
мэргэжилтэн



Г.Лувсан-Одсэр

Иргэний нисэхийн ерөнхий газрын
дарга



Ч.Мөнхтуяа

Хянасан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга



Ч.Одгэрэл

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
Төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн



Б.Энх-Амгалан

Боловсруулсан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
нисэх буудлын бодлогын
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн



Э.Мөнх-Эрдэнэ



2024..... оны 05-р сарын 01-ны өдрийн
14..... дугаартай зургийн даалгавар



"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫГ ДАГАСАН НИСЭХ БУУДЛЫН ЗОРЧИГЧ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БОЛОН БУСАД ИНЖЕНЕРИНГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖУУДЫН ИЖ БҮРЭН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Д/д	Тайлбар	Ерөнхий шаардлага
1. Зорчигч үйлчилгээний барилга		
1.1	Барилга байгууламжийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - Цагт 1100 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай байх. - Олон улсын 4 хүзүүвч /gate/, орон нутгийн 2 хүзүүвчтэй байх
1.2	Ерөнхий төлөвлөгөөнд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Олон улсын агаарын тээвэрлэгчийн холбоо /IATA/-ноос гаргасан нисэх буудлыг төлөвлөх гарын авлагыг баримтлан төлөвлөх; - Зорчигч үйлчилгээний барилгын орчинд автомашин, такси, нийтийн тээврийн хэрэгслийн ил зогсоолын зай талбай төлөвлөх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан явган хүний зам, гарц, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, барилгад орох орц гарцыг төлөвлөх; - Олон улсын агаарын тээвэрлэгчийн холбоо /IATA/-ноос гаргасан нисэх буудлыг төлөвлөх гарын авлагыг баримтлан олон улс болон дотоодын ирэх/явах зорчигчид, угтагчид, үдэн гаргагчдын хөдөлгөөний урсгал, барилгад орох гарах гарцыг архитектур орон зайн төлөвлөлтөөр оновчтой шийдвэрлэж ерөнхий төлөвлөгөөнд тодорхой тусгах; - Зорчигчид зориулсан зарлан мэдээлэх болон мэдээлэх тэмдэглэгээг төлөвлөх; - Зорчигч үйлчилгээний барилга зорчигчдын тав тухтай нөхцөлийг хангах; - Нислэгийн хөдөлгөөний хяналтын цамхгийг "Air Traffic Control Tower Design & Construction" олон улсын жишиг стандартад нийцүүлэн боловсруулах; - Аэродромын тусгай тоноглолтой болон агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэх машин механизм техникийн үзүүлэлттэй нийцүүлэн гараашийг төлөвлөх; <p>Зорчигч үйлчилгээний барилгын хүчин чадлыг эхний ээлжид 6 хүзүүвч, Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөх агаарын хөлгийн давтамж, олон улсын, орон нутгийн нислэгийн эрчим ихсэж байгааг харгалзан үзэж шинэ нисэх буудлын хэтийн төлөвт хүзүүвчийн тоо, зорчигч үйлчилгээний барилгын талбайг нэмэгдүүлэх боломжтой байхаар ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;</p>
1.3	Архитектур, орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн харагдац, байгаль орчинтой уялдсан, зорчигчдын сэтгэл санаанд нийцсэн өвөрмөц онцлогтой байх; - Нислэгийн хөдөлгөөний хяналтын цамхгийн барилгатай архитектурын нэгдсэн шийдэлтэй байх; - Барилгын зураг төсөл, бүтээцтэй уялдуулж гүйцэтгэх;



		<ul style="list-style-type: none"> - Барилгын гадаад /экстерьер/ нүүрэн тал, дотоод /интерьер/ орон зайн төлөвлөлтийг орон нутгийн онцлогийг илэрхийлсэн, засал чимэглэлд барилгын орчин үеийн материалыг ашиглан барилгын дүр төрхийг нэгтгэн илэрхийлэх;
1.4	Барилгын дотоод орон зайн зохион байгуулалт, шаардлага бүхий өрөө, танхим	<ul style="list-style-type: none"> • Зорчигчдын үйлчилгээний танхимууд <ul style="list-style-type: none"> - Явах болон ирэх зорчигчдод үйлчлэх үйлчилгээний бүсийг хамааралгүйгээр 2 түвшинд, зорчигч урсгал холилдохгүй байхаар төлөвлөх; - Олон улсын болон орон нутгийн зорчигчдод үйлчлэх үйлчилгээний танхимыг хамааралгүйгээр тус тусад нь төлөвлөх; - Олон улсын болон орон нутгийн агаарын тээврийн зорчигчид, угтан авагсад, болон үдэн гаргагчдад зориулсан үйлчилгээ явуулах танхим төлөвлөх; - Зорчигчдыг бүртгэх, ачаа тээшний бүртгэл, олголт хийх танхим төлөвлөх; - Хилийн шалган нэвтрүүлэх, гадаадын иргэн харьяатын асуудал, гааль, гэх мэт бусад хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагааг явуулах танхимууд төлөвлөх; - Дамжин өнгөрөх зорчигчдод үйлчлэх танхим, тээш хадгалах өрөө төлөвлөх; - Явах зорчигчдод зориулсан хүлээлгийн танхим төлөвлөх; - Өндөр зэрэглэлийн зорчигчдод үйлчлэх тусгай үйлчилгээний орц гарц бүхий танхимууд /VIP/ төлөвлөх; - Нийтийн эзэмшлийн талбайг оновчтой, зай ихтэй байхаар төлөвлөх. • Үйлчилгээний бусад танхимууд <ul style="list-style-type: none"> - Ресторан, кафе, цай, зоогийн газар; - VIP lounge; - Үсчин, гоо сайхны салон; - Банк, шуудан, харилцаа, холбооны салбар; - Эмнэлгийн тусламжийн өрөө, эх хүүхдийн өрөө; - Ахуй, соёлын болон худалдаа үйлчилгээний өрөө; - Татваргүй бараагаар үйлчлэх худалдааны танхим; • Оффисын зориулалт бүхий өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Нисэх буудлын албадын ажлын өрөөнүүд; - Агаарын тээврийн компанийн ажлын өрөөнүүд; - Олон улсын агаарын тээврийн компаниудын ажлын өрөөнүүд; - Хил, гааль, мэргэжлийн хяналт, цагдаа, тагнуул болон гадаадын иргэн харьяатын албадын ажлын өрөө; - Буудлын аюулгүй байдлыг хангах харуул, хамгаалалтын албадын өрөөнүүд; - Теле мэдээлэл, холбоо дохиолол, цаг уурын мэдээллийн албадын өрөө; - Үйлчилгээний болон техникийн засварын ажилтнуудын өрөө; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй / БНБД-ийн заалтын дагуу; - Зарлан мэдээлэх өрөө.



1.5	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц, материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох ба барилгын хүчин чадлыг өргөтгөх боломжтой хийц бүтээцээр төлөвлөх; - Монгол Улсын стандарт болон ИКАО-ийн шаардлагад нийцэх орчин үеийн байгаль орчинд ээлтэй эко барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх.
1.6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Усан болон агаарын халаалтын системтэй; - Ердийн болон механик салхивч агааржуулалтын системтэй; - Цэвэр усны эх үүсвэр нь төвийн эсхүл нисэх буудлын цэвэр усны байгууламжаас; - Бохир усыг төвийн эсхүл нисэх буудлын ариутгах байгууламжтай холбох; - Үйлчилгээний танхим, ажлын өрөө, бусад эх үүсвэрээс гарах хог хаягдлыг төвлөрүүлэн цуглуулах системийг төлөвлөх; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байх; - Интернэт шилэн кабелиар холбох, хяналтын камер, галын болон бусад дохиолол төлөвлөсөн байх.
1.7	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Хүн тээврийн болон ачаа тээврийн зориулалттай лифт төлөвлөх; - Хүн тээврийн зориулалттай эскалатор; - Олон улсын болон орон нутгийн ачаа тээшийг богино хугацаанд тээвэрлэх хөдөлмөр, цаг хугацаа хөнгөвчилсөн конвейер төлөвлөх; - Ачаа тээшний иж бүрэн систем.
1.8	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч иргэдийн тав тухтай нөхцөлийг хангах асуудлыг тусгах; - Ачаа тээш ачиж буулгах, зөөж тээвэрлэх, үйл ажиллагааг хөдөлмөр хөнгөвчлөх боловсронгуй аргаар шийдвэрлэж, ачаа тээшийг зорчигчдод богино хугацаанд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх; - Зорчигч үйлчилгээний барилгын хүзүүвч нь битүүмжлэл сайтай, халаалт, хөргөлтийн системтэй, зорчигчийн тав тухыг хангах орчин үеийн дэвшилтэд технологид нийцсэн байх; - Зорчигч үйлчилгээний барилга нь эко, байгаль орчинд ээлтэй, смарт шийдэлтэй байх.
1.9	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ; - Галын аюулаас хамгаалах асуудал, онцгой тохиолдолд хүмүүсийг богино хугацаанд барилгаас гаргах нөхцөлийг тусгах.



2. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын барилга, хяналтын цамхаг		
2.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	<ul style="list-style-type: none"> - Нислэгийн хөдөлгөөний удирдлагын барилга, хяналтын цамхаг нь хөөрөх буух зурвас болон аэродромын бүхий л элементүүдийг стандарт шаардлагын дагуу бүрэн ажиглах боломжтой байх.
2.2	Ажиллах горим, өрөө тасалгаанд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Аэродромын бүсэд орж ирсэн агаарын хөлгийг удирдлагаар хангах, буулт хөөрөлтийг удирдах, зурвас дээрх хөдөлгөөний хяналт, аэронавигаци холбоо, гэрэл суултын систем, дохиоллоор хангах зориулалтаар ашиглахаар төлөвлөх; - Хяналтын цамхгийн өндрийг нь хөөрөх буух зурвасын төгсгөлийн цэг болон зорчигч үйлчилгээний барилгын өмнөх талбайд зогсох агаарын хөлгүүд харагдахуйцаар төлөвлөх; - Гадна ба дотор засал чимэглэл нь архитектур төлөвлөлт болон технологийн шаардлагыг хангасан байх ба гадна засал нь аэродромын зурваст байгаа агаарын хөлгийн нисгэгчдийн хараанд нөлөөлөхгүй /гялбахгүй/ байхаар төлөвлөх; - Барилгын орон зайн төлөвлөлт, барилга бүтээцийн шийдлүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Зураг төслийн ажигд ИКАО-гаас тавигдсан барилга угсралтын шаардлагыг ханган төлөвлөх; - Цамхгийн удирдлагын өрөөний гэрэлтүүлгийг бууруулах, өсгөх боломжтой байхаар хийгдсэн байх ба таазанд хотгор хэлбэртэйгээр суурилсан, чиглэлийг нь тааламжтай хэмжээнд тохируулдаг байхаар төлөвлөх; - Цамхгийн удирдлагын өрөөний дотор шалны материал нь ус нэвтэрдэггүй /усны хамгаалалттай/, дуу чимээ тусгаарладаг, долгионы хамгаалалттай, галд тэсвэртэй байх; - Ойртолтын удирдлагын өрөө, захиргааны өрөөнүүд, сургалтын анги танхим, хурлын танхим, амралтын өрөө, хувцасны өрөө, холбооны тоног төхөөрөмжийн өрөө, бодит ажиглалтын системийн сургалт дадлагын өрөө болон бусад нэгжүүд цамхгийн үндсэн байгууламж дотор байрлахаар төлөвлөх.
2.3	Шаардлагатай өрөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> - Хяналтын цамхагт агаарын хөлгийн хяналт хариуцсан техник хангалтын албаны ажлын өрөөг төлөвлөх; - 11Р8-ын өрөөг стандарт норм дүрмийн дагуу төлөвлөх; - Цаг уурын бодит ажиглалтын өрөөний хаалга 1,4м-ээс багагүй өргөнтэй байх; - Цамхгийн дээд хэсэгт хяналтын задгай талбай төлөвлөх; - Үүрэгт ажлаасаа аль болох богино хугацаагаар хөндийрөх, ажлын чадвар бууруулахгүй байх шаардлагад нийцсэн ариун цэврийн өрөөг хяналтын цамхагт төлөвлөх.
2.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтэц материал	<ul style="list-style-type: none"> - Барилга нь онцгой объект тул технологийн болон галын аюулгүй байдал, газар хөдлөлийн шаардлагын дагуу барилга бүтээцийн шийдэл, материалыг төлөвлөх;

Бүртгэлийн дугаар 213
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛБАР ҮНӨН
 Хуулбар олгосон амьтны гарын үсэг
 2024 оны 05 сарын 05 өдөр

		<ul style="list-style-type: none"> - Хяналтын цамхгийн хашлага хийцийг ажиллагсдын тав тухтай байдлыг хангах зорилгоор агаарын хөлгийн дуу чимээг тусгаарласан байхаар төлөвлөх; - Орчин үеийн шинэ барилгын технологи, материалыг холбогдох норм дүрэмд нийцүүлэн төлөвлөх; - Барилгын суурийг инженер геологийн судалгааг үндэслэн хийхээс гадна барилга угсралтын ажлыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэхээр төлөвлөх; - Хяналтын цамхгийн агаарын хөлгийн хяналтын албаны ерөөний шилэн витражийг стандарт нормын дагуу гэрэл бууруулах болон үл цантах шилээр, дуу чимээ намсгагч тусгаарлагчтай байхаар төлөвлөх; - Техникийн ерөөнүүдэд цахилгаан, холбооны холболт хийх боломжтой "access floor" маягийн шал төлөвлөх.
2.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийх.
2.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Хяналтын цамхагт хүн тээврийн зориулалттай лифт төлөвлөх; - Аюулгүй байдлын зай талбай төлөвлөх; - Автомашин зогсоол, ногоон байгууламж төлөвлөх.
2.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхаг нь онцгой объект тул хамгаалалттай нэвтрэх систем төлөвлөх; /автомат/ - Газар хөдлөлийн баллыг онцгой объектоор тооцох; - Цамхгийг хүрээлсэн цонхны шилэнд туссан нарны тусгал болон бусад гэрлийн хугарлыг хамгийн бага хэмжээнд байхаар тооцох; - Цамхгийн цонхны тавцан нислэгийн удирдагчид саад болохгүй нам өндөртэй байх.
2.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээцийн болон гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийх.
3. Захиргааны барилга		
3.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	<ul style="list-style-type: none"> - Ажилчдын тоо болон захиргааны барилгын хүчин чадлыг техник эдийн засгийн үндэслэлд тусгасан байдлаар төлөвлөх.
3.2	Ажиллах горим, ерөө тасалгаанд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Нисэх буудлын захиргааны албан хаагчдын оффисын зориулалттай; - Ажлын ерөөнүүд; - Ажлын байрны талбайнууд; - Давхрын өндөр; - Хонгилын өргөн;
3.3	Шаардлагатай ерөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> - Уулзалтын танхим; - Хурлын танхим; - Оффисын ерөөнүүд; - Архивын ерөө; - Цайны газар; - Инженер техникийн ерөөнүүд; - Ариун цэврийн ерөө;



		<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл лавлах өрөө; - Харуул хамгаалалтын алба;
3.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох; - Монгол Улсын стандарт норм дүрмийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн суурийн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх.
3.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Усан болон агаарын халаалтын системтэй; - Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй; - Цайны газарт утаа, уур сорогч төлөвлөх; - Цэвэр усны эх үүсвэр төвөөс эсхүл нисэх буудлын цогцолборын цэвэр усны байгууламжаас хангагдах; - Бохир усыг төвөөс эсхүл нисэх буудлын цогцолборын ариутгах байгууламжтай холбохоор төлөвлөх; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэнэ; - Барилгын цахилгаан хангамжийн нөөц эх үүсвэрийг зорчигч үйлчилгээний барилгын хамт төлөвлөх; - Интернэт шилэн кабелиар холбох; - Хяналтын камер, чанга яригч, дохиолол төлөвлөсөн байх.
3.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Автомашин зогсоол, ногоон байгууламж төлөвлөх.
3.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Захиргааны барилгын ажилчдын урсгалыг зорчигч үйлчилгээний барилгатай хэрхэн уялдуулах талаар зөв шийдэл тусгах.
3.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
4. Ачаа шуудан тээврийн үйлчилгээний барилга		
4.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	<ul style="list-style-type: none"> - Жилийн олон улсын ачаа эргэлтийн хэмжээг ТЭЗҮ-д үндэслэж, хүчин чадлыг тодорхойлох; - Жилийн орон нутгийн ачаа эргэлтийн хэмжээг ТЭЗҮ-д үндэслэж, хүчин чадлыг тодорхойлох; - Олон улсын болон орон нутгийн ачааны агуулах, оффисын байр төлөвлөх; - Өргөтгөл хийх боломжтойгоор төлөвлөх; - Ачааны агуулахын 1м² талбайн даацыг норм, стандартын дагуу төлөвлөх.



4.2	Ажиллах горим, өрөө тасалгаанд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Олон улсын болон орон нутгийн ачаа хүлээн авч хадгалах, илгээх, олгох үйл ажиллагаа явуулахаар төлөвлөх; - Олон улсын болон орон нутгийн ачааг тусгаарлах боломжийг бий болгох; - Үйлчилгээний ажилтнуудын хөдөлмөр зохион байгуулалтыг хялбарчлах; - Олон улсын болон орон нутгийн ачааны хүлээн авах, хадгалах, үйлчилгээний талбайг оффистой зэрэгцээ байхаар төлөвлөх; - Хүлээн авах ачааны хэмжээ илгээх ачаанаас их байдаг нөхцөлийг тооцож, дотоод зохион байгуулалтыг төлөвлөх; - Харуул хамгаалалтын байрыг төлөвлөхдөө ачаа хүлээн авах, илгээх цэг, тээврийн хэрэгсэлд хяналт тавих боломжтой нөхцөлийг бүрдүүлэх; - Ачаа шуудан тээврийн барилгын ачаа хүлээн авах хаалганы өндөр, өргөнийг норм дүрмийн дагуу төлөвлөх. - Ачааны тавиурын байршил, хоорондын зай, өндрийг норм дүрэмд заасны дагуу төлөвлөх; - Ачигч механизмын зогсоолыг агуулахад төлөвлөх. - Өрөө тасалгаануудын зохион байгуулалт, байршил, инженерийн хангамж нь олон улсын стандарт норм дүрмийн дагуу төлөвлөх.
4.3	Шаардлагатай өрөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> • Техникийн өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Механикийн өрөө; - Генераторын өрөө; - Өндөр нам хүчдэлийн өрөө; - Холбооны самбарын өрөө; - Галын усны насосын өрөө; - Цахилгааны самбарын өрөө; • Үйлчилгээний өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний ажилчдын хувцас солих өрөө; шүршүүрийн хамт - Амралтын өрөө; - Цайны газар; - Хүлээлгийн танхим; • Агуулахууд <ul style="list-style-type: none"> - Хөлдөөгч агуулах; - Хүйтэн агуулах; - Ургамал амьтны гаралтай бүтээгдэхүүн, эм вакцин хадгалах агуулах; - Үнэт эд бүхий ачааны агуулах; - Тусгай зориулалтын ачаа тээшний агуулах; - Аюултай ачааны агуулах; - Ачаа тээшний агуулах; - Гаалийн баталгаат агуулах; - Гаалийн түр агуулах; - Гаалийн хяналт, ачаа тээш олгох, хүлээлгэн өгөхөд зориулсан талбай. • Гааль, мэргэжлийн хяналт, болон бусад албан өрөө, танхимууд <ul style="list-style-type: none"> - Экспорт импортын нярвын өрөө; - Гаалийн байцаагчдын өрөөнүүд; - Гаалийн мэдүүлгийн үйлчилгээний танхим; - Мэргэжлийн хяналтын үйлчилгээний өрөө;



		<ul style="list-style-type: none"> - Тээвэр зуучийн үйлчилгээний өрөө; - Агаарын Тээврийн компаниудын өрөө;
4.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох; - Монгол Улсын стандарт болон ИКАО-ийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн суурийн бүтээцийг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Агуулахын барилгын хүчин чадлыг өргөтгөх боломжтойгоор барилгын хийц бүтээцийг төлөвлөх; - Ачигч механизм болон тэргэнцрүүдийн хөдөлгөөнд хийц бүтээцийн элементүүд /багана, бусад/ саад учруулахгүй байхаар барилгын бүтээцийг шийдвэрлэх.
4.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станцаас эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Агуулахын тооцроот температур +12°C; - Усан болон агаарын халаалтын системтэй байх; - Хаалганд дулаан тусгаарлах халуун агаарын хөшиг төлөвлөх; - Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй; - Цэвэр усны эх үүсвэр нь төвөөс эсхүл нисэх буудлын цэвэр усны байгууламжаас; - Бохир усыг төвтэй эсхүл нисэх буудлын ариутгах байгууламжтай холбоно; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байх; - Агуулахад ачигч механизмын цэнэглэгч бэлтгэх; - Хөргөгч агуулахад хүйтэнд тэсвэртэй цахилгааны тоног төхөөрөмж төлөвлөх; - Интернэт шилэн кабелиар холбох; - Хяналтын камер, чанга яригч, дохиолол төлөвлөсөн байх.
4.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Том оврын болон хүнд жинтэй ачааг хадгалах талбай, атмосферын уснаас хамгаалах саравчийг төлөвлөх; - Ачаа тээврийн том оврын автомашины зогсоолыг төлөвлөх; - Ачаа зөөвөрлөх, өргөх, байршуулах тоног төхөөрөмжийг норм стандартын дагуу төлөвлөх; - Ачааны пүүг технологийн дагуу байршуулж төлөвлөх; - Агуулахад ачаа бараа зөөх зориулалттай 5тн хүртэлх даацтай ачаа өргөгч төлөвлөх;
4.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Ачааны тээврийн хэрэгслийн уртыг 12м-ээс багагүйгээр тооцож замын эргэлтийн радиус, зогсоолыг төлөвлөх; - Барилгаас перрон руу шууд гарах гарц болон пүү байрлах зай талбай төлөвлөх;
4.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийх;



		- Галын гидрантын нөөц усны сав төлөвлөх.
5. Гал унтраах авран хамгаалах албаны барилга		
5.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	<ul style="list-style-type: none"> - Гал унтраах авран хамгаалах албаны барилга нь доорх хэсгээс бүрдэнэ. <ul style="list-style-type: none"> • Гал унтраах авран хамгаалах албаны захиргааны барилга; • Гал унтраах авран хамгаалах 3 машин, командын болон түргэн тусламжийн машины гарааш; • Гадна биеийн тамир, сургалтын талбай.
5.2	Ажиллах горим, өрөө тасалгаанд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн гал унтраах, авран хамгаалах үйл ажиллагааг шуурхай явуулж, шаардлагатай тоног төхөөрөмжид, засвар үйлчилгээ хийхээр төлөвлөх; - Өрөө тасалгаа, агуулахын талбайг норм стандартын дагуу тооцоолж төлөвлөх; - Гал унтраах, авран хамгаалах үйл ажиллагааг хянах өрөөг төлөвлөх; - Галын машин болон барилгын хашлага хийц хоорондын зайг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Гараашны хаалганы өргөн галын машины өргөнөөс 1 м илүү байх ба богино хугацаанд онгойлгох боломжтой байх; - Гараашны хаалганы дээд хэсэгт хаалганы 30% багагүй талбайтай шилэн цонх байх; - Галын 3 машин тутамд гараашинд засварын суваг төлөвлөнө.
5.3	Шаардлагатай өрөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> • Техник үйлчилгээний болон Гараашны зориулалттай өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Цахилгааны өрөө; - Холбооны өрөө; - Механикийн өрөө; - Галын насосын өрөө; - Гал унтраах автомашины гарааш; - Засвар үйлчилгээний өрөө; - Командын болон түргэн тусламжийн машины гарааш; - Багаж хэрэгслийн засвар, ажлын өрөө; • Агуулахын өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Химийн бодисын агуулах; - Аж ахуйн болон хувцас хэрэглэлийн агуулах; - Гал унтраах хөөсний агуулах; - Тусгай зориулалттай утааны баг хадгалах өрөө; • Сургалтын өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Онол сургалтын танхим, компьютерын өрөө; - Бие чийрэгжүүлэх танхим; - Дасгалжуулагчийн өрөө; - Эмчийн өрөө; - Лекцийн танхим; • Гал сөнөөх албаны өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Дуудлага хүлээн авах, хяналтын өрөө; - Ажилчдын цайны газар; - Унтлагын өрөө; - Хувцас солих өрөө; - Хувцас цэвэрлэх, хатаах өрөө; • Удирдлагын албаны өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Даргын өрөө; - Менежерийн өрөө;



		<ul style="list-style-type: none"> - Мэргэжилтний өрөө; • Бусад туслах өрөөнүүд <ul style="list-style-type: none"> - Ариун цэврийн өрөө; - Шүршүүрийн өрөө; - Үйлчлэгчийн өрөө;
5.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох; - Монгол Улсын стандарт норм дүрмийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх.
5.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Гал унтраах авран хамгаалах ангийн Гараашны дотор агаарын температур +16°; - Усан болон агаарын халаалтын системтэй; - Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй; - Шаардлагатай зарим өрөөнд агаар халаах, хөргөх төхөөрөмж төлөвлөх; - Галын автомашин бүрээс утаа зайлуулах төхөөрөмж төлөвлөх; - Цэвэр усны эх үүсвэр нь төвөөс эсхүл нисэх буудлын цэвэр усны байгууламжаас хангагдахаар төлөвлөх; - Гал унтраахад зориулсан нөөц усны сав төлөвлөх; - Галын автомашинд зориулсан нөөц усны сав төлөвлөх; - Галын автомашиныг усаар цэнэглэх шахуургатай систем төлөвлөх; - Бохир усыг төвтэй эсхүл нисэх буудлын ариутгах байгууламжтай холбоно; - Бохир ус зайлуулах системд тос барих шүүгч тавих; - Давхар бүрд ариун цэврийн өрөө төлөвлөх; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байх; - Интернэт шилэн кабелиар холбох; - Хяналтын камер, чанга яригч, дохиолол төлөвлөсөн байх; - Зарлан мэдээлэх, түгшүүр дохиоллын төхөөрөмжийг өрөө бүрд төлөвлөх.
5.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Барилгын орчинд автомашины зогсоол, гудамжны гэрэлтүүлэг төлөвлөх; - Гал унтраах авран хамгаалах албаны эзэмшлийн талбайн 15% багагүй талбай нь ногоон байгууламж байхаар төлөвлөх;
5.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Гал унтраах, авран хамгаалах албаны барилгыг нислэгийн талбайн бүсэд тогтоосон хугацааны дотор хүрч, үйл ажиллагаа явуулах боломжтой байршлыг сонгон төлөвлөх.
5.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал,



		бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
6. Цэвэр усны байгууламж		
6.1	Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - Шинэ нисэх буудлыг унд-ахуйн болон технологийн усаар хангах тоног төхөөрөмж, шаардлагатай барилга байгууламжийг төлөвлөнө; - Цэвэр усны хэрэглээг барилга байгууламжийн хэрэгцээнд зориулж төлөвлөх.
6.2	Ус хангамжийн сүлжээний эх үүсвэр, ус олборлох байгууламж	<ul style="list-style-type: none"> - Ус хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо байр зүйн ба гидрологи, гидрогеологи, усны хими, усны биологи, усны дулаан бусад хайгуул шинжилгээний болон эрүүл ахуйн шинжилгээг үндэслэх; - Газар доорх усыг олборлоход өрөмдмөл гүний худгийн байгууламжийг ашиглана; - Худгийн амсарт байрлах тоног төхөөрөмжүүдийг газар доорх камерт байрлуулна. Газар доорх өрөөний хэмжээг цахилгаан хөдөлгүүр, тоног төхөөрөмжүүд, хянах хэмжих багажуудын байрлалаас хамааруулан тооцох бөгөөд өрөөний өндөр 2.4 м- ээс багагүй байх; - Худгийн насосыг угсрах, засварлах, задлахад зориулсан цооногийн амсар дээр байрлах механик хэрэгслийг ашиглах тагийг барилгын таазанд байрлуулна; - Ус хангамжийн системийн найдвартай ажиллагааг хангах, худгийн байгууламжийн засвар үйлчилгээ хийх нөхцөлийг харгалзан хамгийн багадаа 1 нөөцийн худаг нэмж төлөвлөнө. Нисэх буудлын хоногийн нийт усны хэрэглээ болон худгийн гарцыг тооцон худгийн тоог тогтооно; - Нэгдүгээр өргөгчийн барилгын гадуур хашаатай байхаар төлөвлөх; - Унд-ахуйн усны чанар нь MNS900-2005-ын шаардлагыг хангасан байна. Нөөцийн хувьд усны хамгийн их хэрэгцээг хүрэлцээтэй хугацаанд хангаж чадахуйц байвал зохино.
6.3	Ус бэлтгэлийн станц	<ul style="list-style-type: none"> - Усыг цэвэрлэх арга, цэвэрлэх байгууламжийн бүтэц, тооцооны үзүүлэлтүүд, урвалжийн тооцоот тун зэргийг ус хангамжийн эх үүсвэрийн усны чанар, ус дамжуулах хоолойн зориулалт, станцын хүчин чадал, орон нутгийн нөхцөл, технологийн судалгаан дээр үндэслэх; - Ус бэлтгэх станцад хими, биологийн лаборатори, урвалж хадгалах өрөө, ажлын өрөө, тоног төхөөрөмжийн засварын өрөө, эрүүл ахуй техникийн үзэл зэргийг төлөвлөх; - Урвалжийн агуулахыг 30 хоногийн нөөцтэй хадгалахаар тооцох; - Станцад ашиглах урвалжууд болон шүүлтүүрүүдийн агуулахын багтаамж, хэмжээ, байршил, хадгалах горимыг БНБД -д заасны дагуу төлөвлөх; - Станц болон агуулах дотор урвалж тээвэрлэх, буулгах ажлыг механикжуулсан байх; - Ус цэвэршүүлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг эрчим хүчний хэмнэлттэй, үйл ажиллагааны зардал бага бөгөөд ашиглахад хялбар байх зарчмыг үндэслэн сонгох;



		<ul style="list-style-type: none"> - Шүүлтүүр болон халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийг төлөвлөх; - Насосын хийц, төрөл ба ажлын насосын тоог дамжуулах хоолой, шугам сүлжээ, тохируулах эзлэхүүн, хоногийн ба цагийн ус хэрэглээний графикууд, гал унтраах нөхцөл зэргийг үндэслэн тогтооно.
6.4	Дамжуулах хоолой, шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> - Дамжуулах хоолойг засварлах хугацаа болон ус хангамжийн сүлжээний ангиллаас хамааруулж тоог тогтоох; - Дамжуулах ба түгээх сүлжээнд тавигдах хоолойн материалыг статик тооцоо, дамжуулах усны чанар, ажиллах нөхцөл болон хөрсний шинж чанарыг хамааран сонгох; - Дамжуулах хоолойн суулгалтын гүнийг хөрсний температур "тэг" болох тооцоот хамгийн гүн болон дулаан техникийн тооцоог үндэслэн тооцох.
6.5	Ус хадгалах эзлэхүүний байгууламжууд	<ul style="list-style-type: none"> - Ус хадгалах эзлэхүүний байгууламжийг хоногийн усны хэрэглээ болон гадна гал унтраах системийн хэрэглээн дээр үндэслэн төлөвлөх; - Эзлэхүүний байгууламжууд, тэдгээрийн тоног төхөөрөмжүүдийн усыг хөлдөлтөөс хамгаалахаар төлөвлөх; - Эзлэхүүний байгууламжуудыг ус өгөх, авах хоолой, хүн орох болон тоног төхөөрөмж зөөхөд зориулж таг, гишгүүр шат, усны түвшин өөрчлөгдөхөд агаар оруулж гаргахад зориулсан агаар сэлгэлтийн төхөөрөмжөөр тоноглоно; - Ундны усанд зориулсан усан сангийн бүх тагууд нь бүрэн битүүмжлэлтэй байх шаардлагатай.
6.6	Барилга, байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, үндсэн бүтээц, материал	<ul style="list-style-type: none"> - Усан хангамжийн барилга байгууламжийн байрлалыг БНБД 11-89-90-д заагдсан шаардлагатай нийцүүлэн төлөвлөх; - Хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын агуулахын байрлалыг БНБД 11-89-10-д заасны дагуу сонгох; - Усан хангамжийн бүх барилга байгууламжууд хашаатай байх; - Усан хангамжийн барилга байгууламжийн эзлэхүүний төлөвлөлт, хийцийн шийдлийг БНБД -н дагуу тооцох. - Эзлэхүүний байгууламжийг цутгамал төмөр бетоноор эсвэл угсармал төмөр бетоноор угсарна; - Эзлэхүүний байгууламжийн хашлага хийц нь гидравлик сорилтод тавигдах шаардлагыг хангасан, атмосферийн ба ул хөрсний ус, тоос шорооноос бүрэн хамгаалагдсан байх шаардлагатай; - Барилгын хийцийг зэврэлтээс хамгаалах, төмөр бетон хийцийг цахилгаан химийн зэврэлтээс хамгаалах арга хэмжээг авна.
6.7	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Усан хангамжийн барилга байгууламжийн дулаан хангамжийг дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Усан болон агаарын халаалтын систем ашиглана; - Өрөө, тасалгаа, байгууламжийн халаалтын үеийн дотор агаарын температур, агаар солилцооны давтамж, гэрэлтүүлгийн чадварыг БНБД 40-02-06 -ын хүснэгт 44-д заасныг үндэслэнэ;



		<ul style="list-style-type: none"> - Бохир усыг нисэх буудлын ариутгах байгууламжтай холбоно; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байна.
6.8	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламж инженерийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ зэргийг засварлах угсрах машин механизм, тээврийн хэрэгсэлд зориулагдсан зам, талбайг төлөвлөнө.
6.9	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Усан хангамжийн барилгыг байгаль, цаг уурын онцгой нөхцөлд зохицуулан төлөвлөх шаардлагатай.
6.10	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээцийг төлөвлөж, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
7. Цэвэрлэх байгууламж		
7.1	Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадал,	<ul style="list-style-type: none"> - Шинэ нисэх буудлаас гарах ахуйн бохир усыг цэвэрлэх тоног төхөөрөмж, шаардлагатай барилга байгууламжуудыг төлөвлөх; - Нисэх буудлын барилга байгууламжийн хүчин чадалд нийцүүлж бохир усны хэмжээг төлөвлөх.
7.2	Цэвэрлэх байгууламж	<ul style="list-style-type: none"> - Нисэх буудлын бохир ус цэвэрлэх байгууламжийн төрөл болон байршлыг тухайн газрын геологи гидрогеологи ба эрүүл ахуйн нөхцөл дээр үндэслэн барилгын норм дүрмийн дагуу сонгоно; - Цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологийг Монгол Улсын стандарт MNS 4288:1995 "Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага"-ын дагуу төлөвлөнө; - Хэрэглээний бохир усыг Монгол Улсын стандарт MNS 4943:2000 "Усны чанар, хаягдал бохир усны стандартад заасан усны эх үүсвэрт хаяж болох хаягдал усанд тавих шаардлага"-ын дагуу төлөвлөнө.
7.3	Бохир усны шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> - Хаягдал бохир ус цуглуулах хоолойг PVC зэрэг зэвэрдэггүй материалаар төлөвлөх; - Барилга, байгууламжаас хаягдал бохир ус цуглуулах хоолойн хэмжээг оргил цагийн урсац болон шугамын налуугаас хамаарах урсцын хурднаас хамааруулан тооцож сонгох; - Эдийн засгийн болон техникийн асуудлуудыг харгалзан, бохир усны өргөгч насосын станц(ууд)-ыг зохих байршлаар төлөвлөнө; - Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэршүүлсэн хаягдал усыг зайлуулах насосыг цэвэрлэх байгууламжид төлөвлөх ба цэвэрлэсэн усыг ойр байрлах голд нийлүүлнэ.
7.4	Бохир ус цэвэрлэх дамжлагын эзлэхүүний байгууламжууд	<ul style="list-style-type: none"> - Бохир усны цутгалангийн хэлбэлзлийг шингээх зориулалтаар жигдрүүлэх санг төлөвлөнө; - Биологийн аргаар цэвэрлэх зориулалттай агааржуулах сав /аэротанк/-ийг төлөвлөнө. Бохир усыг идэвхт лагтай эргэлдүүлэн агааржуулах замаар, бохир усан дахь органик нэгдлүүдийг лаг болгоно;



		<ul style="list-style-type: none"> - Цэвэрлэсэн усыг лагаас салгах зориулалттай тунгаагуурыг төлөвлөх ба тунгалагжуулсан усыг тунгаагуураас хоёрдогч тунгаагуур /тунгалагжуулсан ус хураах сан/-д шилжүүлэх, лагтай хэсгийг лаг усгүйжүүлэх байгууламжид шилжүүлэхээр төлөвлөнө; - Тунгалагжуулсан ус хураах санг төлөвлөнө; - Халдваргүйжүүлэх байгууламжийг технологийн дагуу төлөвлөнө.
7.5	Барилга, байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, үндсэн бүтээц, материал	<ul style="list-style-type: none"> - Цэвэрлэх байгууламжийн бүрдэл, өрөө тасалгааны талбай бүтцийг Барилгын норм дүрэмд заасны дагуу төлөвлөнө; - Барилгын хийцийг зэврэлтээс хамгаалах, төмөр бетон хийцийг цахилгаан химийн зэврэлтээс хамгаалах арга хэмжээг авна; - Цэвэрлэх байгууламжийн барилгын эзлэхүүний төлөвлөлт, бүтээц, материалын шийдлийг БНБД-г мөрдөнө; - Цэвэрлэх байгууламжийн өрөөнүүдийн ариун цэврийн зэрэглэлийг технологиос хамааруулан тогтоож, үйлдвэрлэлийн шат дамжлагын ариун цэврийн шинжийн ангиллын дагуу төлөвлөнө.
7.6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Цэвэрлэх байгууламжийн дулаан хангамжийг нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдахаар төлөвлөх; - Усан болон агаарын халаалтын систем ашиглана; - Өрөө, тасалгаа, байгууламжийн халаалтын үеийн дотор агаарын температур, агаар солилцооны давтамж, гэрэлтүүлгийн чадварыг БНБД 40-02-06, үндэслэнэ; - Лагийг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байна; - Цахилгаан тоног төхөөрөмж, технологийн хяналт, удирдлагын систем ба автоматжуулалтыг барилгын норм дүрэм, стандартын дагуу төлөвлөнө.
7.7	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламж инженерийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ зэргийг засварлах угсрах машин механизм, тээврийн хэрэгсэлд зориулагдсан зам, талбайг төлөвлөнө.
7.8	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгөөс болон бохирын цооногоос гарсан хаягдал усыг зориулалтын автомашинаар цуглуулж, цэвэрлэх байгууламжид нийлүүлнэ; - Байгаль, цаг уурын ба байгалийн онцгой нөхцөлд ариутгах татуургын сүлжээнд тавих шаардлагуудын дагуу төлөвлөлт хийнэ.
7.9	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээцийг төлөвлөж, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.



8. Дулааны станцын		
8.1	Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - Шинэ нисэх буудлын барилга байгууламжуудыг дулаанаар хангах хатуу түлшний зуух, тоног төхөөрөмж, шаардлагатай өрөө тасалгаанууд багтах багтаамжтай байх; - Дулааны зуухны зориулалт нь хэрэглэгчийн халаалт, халуун ус хангамж, агаар сэлгэлтийн системийн шаардлагатай дулааны ачааллыг хангах; - Дулааны эрчим хүчээр тасралтгүй хангагдах найдваржилтын 1 зэрэг
8.2	Ажиллах горим, шаардлагатай өрөө тасалгаа, техникийн өгөгдөл	<ul style="list-style-type: none"> - Зуухны барилга нь хатуу түлшний усан халаагуурт зуухтай гол байгууламж, түлшний агуулах, түлш зөөвөрлөх конвейер, үнс шаарга зайлуулах байгууламж, цахилгааны дэд станц, технологийн ус бэлтгэх төхөөрөмж, материалын агуулах, лаборатори зэргээс бүрдэнэ; - Гадна агаарын тооцооны температурыг барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтийн норм ба дүрмийн дагуу БНБД 2.01-0.1-93 <ul style="list-style-type: none"> - Сүлжээний өгөх усны тооцооны температур 135°C - Сүлжээний буцах усны тооцооны температур 70°C - Зуухны барилгад даргын өрөө, угаалтуур бүхий ажилчдын хувцас солих өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөө, эд хогшлын агуулах, хооллох өрөө, зуухны хяналт удирдлагын өрөө зэргийг төлөвлөнө; - Барилгад орчин үеийн дэвшилтэт техник, технологийг сонгох; - Түлш бэлтгэж дамжуулах, нойтон үнс зайлуулах, ус бэлтгэлийн системүүдийг иж бүрнээр төлөвлөх; - Түлшний нөөцийг 7 хоногоор тооцож түлш хадгалах агуулахыг төлөвлөх.
8.3	Дулаан зуух болон туслах тоноглолд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Усан халаагууртай хатуу түлшний зуух байна. - Зуухны утааны янданг нэг маягийн зураг төслөөр гүйцэтгэнэ; - Утааны янданг өндрийн байгууламжид тавигдах Иргэний нисэхийн дүрэмд нийцүүлэх; - Хатуу түлшний зууханд утааны хийг үнслэгээс цэвэрлэх төхөөрөмж төлөвлөнө. - Ус халаах зуух болон ус халаагуур сүлжээний насостой холбогдох дулаан хангамжийн сүлжээний өгөх ба буцах дамжуулах хоолой нь стандартын шаардлага хангаж байх ёстой.
8.4	Дулаан хангамжийн сүлжээ	<ul style="list-style-type: none"> - Дулааны сүлжээний трасс болон угсрах аргуудыг газрын хөрсний байдал, орчны тохижилт, газар доорх бусад инженерийн байгууламжуудтай уялдуулан, БНБД 41-02-05, БНБД10-01-98 ба СНиП 11-89-80-ын заалтуудын дагуу сонгоно; - Дулааны сүлжээний материал, дамжуулах хоолой ба арматурыг уур ба усны дамжуулах хоолойг барьж байгуулах ба аюулгүй ашиглах дүрэм ба БНБД 41-02-05 -ын шаардлагатай уялдуулна.
8.5	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Зуухны барилгын бүтээц, хашлага хийцийг БНБД-ын дагуу төлөвлөсөн байх; - Зуухны барилгын төлөвлөлт, аль нэг хажуу ханын хийц нь өргөтгөх боломжийг хангасан байна;



		- Зуухны барилгын ханын гадаргууг ус чийг, зэврэлтээс хамгаалсан засалтай байх шаардлагатай.
8.6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулааны зуухны халаалт, агаар сэлгэлтийн системийг БНБД41-01-02 -ын заалтыг баримтална; - Дулааны зуухын өрөө, тасалгааны тооцооны температурыг БНБД41-03-07-ЫН хавсралт 13-д заасныг баримтлан тооцно; - Өрөө тасалгаанд агаар сэлгэлтийн ердийн болон механик систем төлөвлөнө; - Дулааны зуухны барилгын ус хангамжийн системийг БНБД40-01-06, БНБД40-01-06- ийн заалтыг баримтална. - Цэвэр усны эх үүсвэр нь төвөөс эсхүл нисэх буудлын цогцолборын цэвэр усны байгууламж байна; - Ахуйн бохирыг цооногт холбохоор төлөвлөх. - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байна; - Интернэт шилэн кабелиар холбох.
8.7	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	- Дулааны зууханд түлш татах, үнс шаарга зайлуулах тээврийн хэрэгсэлд зориулсан зам талбай байх ба гадна замтай 2 урсгалтай замаар холбогдох шаардлагатай.
8.8	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Үнс, шаарга зайлуулах талбайгаас, атмосферын усаар дамжин цэвэр ус хангамжийн эх үүсвэрийг бохирдуулахаас хамгаалах арга хэмжээг зураг төсөлд тусгах; - Байгаль цаг уурын онцгой нөхцөл болон 7 баллаас дээш газар хөдлөлийн бүсэд зуухны барилга байгууламж төлөвлөхөд тавигдах нэмэлт шаардлагуудыг хангах.
8.9	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Зуухны барилгын гал тэсвэрлэлтийн зэрэг, галын болон шатах, тэсрэх, дэлбэрэх аюултай байдлын зэрэглэлийг БНБД 21-01-02 болон БНБД 41-03-07-ийн Хавсралт4- ийг үндэслэнэ; - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материалыг сонгон бүтээцийг төлөвлөж, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
9. Цахилгааны дэд өртөөний барилга ба дамжуулах шугам		
9.1	Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадал	- Шинэ нисэх буудлын цогцолборын барилга байгууламжуудыг цахилгаанаар хангах төвийн эрчим хүчний системээс 110/10кВ-н агаарын хоёр шугамаар холбогдсон 110/10кВ-н хаалттай хуваарилах цахилгааны үндсэн дэд өртөөний барилга.



9.2	Барилга, байгууламжийн байршил, үндсэн бүтээц, материал	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны дэд өртөөний барилгаас үйлдвэрлэлийн барилга байгууламж болон олон нийтийн барилга хүртэлх зайг БНБД И-89-80 дагуу тодорхойлно; - Цахилгааны дэд өртөөний барилгын өрөө тасалгаа, хаалга гарцын чиглэл, шал болон ханын хийц бүтээц, тоног төхөөрөмжийн байршил, суурийг БД43-101-03-ийг баримтлан төлөвлөнө; - Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохирсон барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн боловсруулах; - Монгол Улсын стандарт норм дүрмийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн суурийн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх.
9.3	Шаардлагатай өрөө тасалгаа	<ul style="list-style-type: none"> - Тоног төхөөрөмжийн өрөө; - Сэлбэгийн агуулах; - Өндөр хүчдэлийн өрөө; - Нам хүчдэлийг өрөө; - Инженер техникийн ажилчдын өрөө; - Ариун цэврийн өрөө; - Даргын өрөө; - Засварын өрөө; - Ажилчдын хувцас солих өрөө; - Цайны өрөө;
9.4	Цахилгаан эрчим хүчийг дамжуулах шугам	<ul style="list-style-type: none"> - Нисэх буудлын барилга байгууламжуудыг кабель шугамаар тэжээнэ; - Кабель шугамын трасс, тавих арга, кабелийн сонголт, холболт, газардуулгыг төлөвлөхдөө БД 43-101-03-ийн шаардлагыг хангана; - Цахилгааны шугам сүлжээг хамгаалах дүрмийг үндэслэн трассын дагуу хамгаалалтын бүсийг тогтооно.
9.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны дэд өртөөний барилгын дулаан хангамжийг нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангана; - Усан болон агаарын халаалтын систем ашиглана; - Агааржуулалт салхивчны системийг БД43-101-03 шаардлагын хангаж төлөвлөнө; - Цэвэр усны эх үүсвэр нь нисэх буудлын цэвэр усны байгууламж байна; - Ахуйн бохирыг цооногт холбохоор төлөвлөх; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Интернэт шилэн кабелиар холбох.
9.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламж инженерийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ зэргийг засварлах угсрах машин механизм, тээврийн хэрэгсэлд зориулагдсан зам, талбайг төлөвлөнө.



9.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Хуваарилах байгууламж нь чийгтэй болон чийг ихтэй байр болон ил агаарт хүрээлэх орчны сөрөг үйлчлэлээс найдвартай хамгаалагдсан байх; - Төхөөрөмжийн ажиллагаанаас үүсэлтэй чичиргээ, гаднын нөлөөгөөр үүсэх доргилтоос тоног төхөөрөмжийн тохируулга алдагдахгүй байхаар төлөвлөх; - Тэсрэх аюултай бүсэд байгаа барилга байгууламж, гадаа байрлуулсан тоноглолыг аянгын шууд цохилт ба хор хөнөөлөөс хамгаалах тухай заавар СН-305-87 дагуу зохион байгуулах;
9.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга нь гал тэсвэрлэлтийн I буюу II зэрэглэлтэй байна; - Гал унтраах тоног төхөөрөмж, дохиоллын системийг БНБД 21-01-02, БД43-101-03-ийг мөрдлөг болгоно.
10. Аэродром үйлчилгээний барилга		
10.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	- Аэродромын үйлчилгээний ажилчдын оффис аэродромын засвар үйлчилгээ арчлалтад шаардлагатай бага болон том оврын машин механизм, тоног төхөөрөмжийн гарааш, материалын агуулахууд.
10.2	Ажиллах горим, өрөө тасалгаанд тавигдах шаардлага	- Аэродромын засвар, үйлчилгээг шуурхай явуулж, тоног төхөөрөмжид, засвар үйлчилгээ хийхээр төлөвлөх
10.3	Шаардлагатай өрөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> - Аэродромын үйлчилгээний машин механизмын Гарааш; - Бага оврын машин механизмын гарааш; - Сэлбэг хэрэгсэл ажлын хувцасны агуулах; - Техник хэрэгслийн агуулах; - Будаг болон химийн бодисын агуулах; - Ажилчдын амралтын өрөө; - Хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөө; - Цайны газар; - Механик цех; - Сургалтын өрөө; - Хяналтын өрөө;
10.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох; - Монгол Улсын стандарт болон ИКАО-ийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн суурийн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх; - Гараашны шалны хийц бүтээцийг машин тоног төхөөрөмжийн овор хэмжээ, хүндийн жингээс хамааруулан сонгох.



10.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдана; - Усан болон агаарын халаалтын системтэй; - Хаалганд дулаан тусгаарлах халуун агаарын хөшиг төлөвлөх; - Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй; - Гараашны хэсэгт утаа сорогч төлөвлөх; - Цэвэр усны эх үүсвэр нь нисэх буудлын цогцолборын цэвэр усны байгууламжаас хангагдана; - Бохир усыг нисэх буудлын цогцолборын ариутгах байгууламжтай холбоно; - Бохир ус зайлуулах системд тос барих шүүгч тавих; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байна; - Интернэт шилэн кабелиар холбох; - Хяналтын камер, чанга яригч, дохиолол төлөвлөсөн байх.
10.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	<ul style="list-style-type: none"> - Автомашины зогсоол - Материал хураах талбай
10.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Том оврын машин механизмын гараашны хаалгыг хялбар нээж хаагдах бүтцийг сонгох. - Шал ханын гадаргууг уур ус тусгаарлагчтайгаар төлөвлөх. - Засварын өрөөнд гүйдэг кран төлөвлөх.
10.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
11. Газрын үйлчилгээний албаны барилга		
11.1	Барилга байгууламжийн хүчин чадал, ангилал зэрэглэл	<ul style="list-style-type: none"> - Газрын үйлчилгээний албаны ажилчдын оффис, агаарын хөлөгт газрын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжийн гарааш, материалын агуулахууд төлөвлөнө.
11.2	Ажиллах горим, өрөө тасалгаанд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлөгт газрын үйлчилгээг шуурхай явуулж, тоног төхөөрөмжид, засвар үйлчилгээ хийх
11.3	Шаардлагатай өрөө тасалгаа, талбай	<ul style="list-style-type: none"> - Газрын үйлчилгээний машин механизмын гарааш; - Токарийн өрөө; - Гагнуурын өрөө; - Техникчидийн өрөө; - Жолооч-операторчдын өрөө; - Сэлбэг хэрэгсэл ажлын хувцасны агуулах; - Тослох материалын агуулах; - Ажилчдын амралтын өрөө; - De/anti-icing шингэн хадгалах агуулах; - Аккумуляторын өрөө; - Хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөө; - Цайны газар; - Механик цех; - Сургалтын өрөө;



		- Хяналтын өрөө
11.4	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох; - Монгол Улсын стандарт болон ИКАО-ийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал, технологи ашиглах; - Инженер геологийн судалгааг үндэслэн суурийн бүтээцийг БНБД-ын дагуу төлөвлөх; - Гараашны шалны хийц бүтээцийг машин тоног төхөөрөмжийн овор хэмжээ, хүндийн жингээс хамааруулан сонгох.
11.5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Дулаан хангамж нь нисэх буудлын дулааны станц эсхүл "Шинэ Хархорум" хотын дулаанаас хангагдана; - Усан болон агаарын халаалтын системтэй; - Хаалганд дулаан тусгаарлах халуун агаарын хөшиг төлөвлөх; - Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй; - Гараашны хэсэгт утаа сорогч төлөвлөх; - Цэвэр усны эх үүсвэр нь нисэх буудлын цогцолборын цэвэр усны байгууламжаас хангагдана; - Бохир усыг нисэх буудлын цогцолборын ариутгах байгууламжтай холбоно; - Бохир ус зайлуулах системд тос барих шүүгч тавих; - Хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэг рүү зөөвөрлөнө; - Цахилгааны хангамж нь төвийн эрчим хүчний системээс тэжээгдэхээс гадна, нөөц тэжээлтэй байна; - Интернэт шилэн кабелиар холбох; - Хяналтын камер, чанга яригч, дохиолол төлөвлөсөн байх;
11.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам, талбай	<ul style="list-style-type: none"> - Автомашины зогсоол; - Ачааны тэргэнцрийн талбай;
11.7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Том оврын машин механизмын Гараашны хаалгыг хялбар нээж хаагдах бүтцийг сонгох; - Шал ханын гадаргууг уур ус тусгаарлагчтайгаар төлөвлөх; - Засварын өрөөнд гүйдэг кран төлөвлөх; - Засварын суваг төлөвлөх;
11.8	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.
12. Техник технологийн болон үйл ажиллагааны зориулалт бүхий туслах барилгууд		



12.1	Барилга байгууламжийн зориулалт	<ul style="list-style-type: none"> • Нислэгийн аюулгүй байдлыг хангах туслах барилгууд <ul style="list-style-type: none"> - Курсын радио маякын байр; - Глисадын радио маякын байр; - Хэт богино долгионы радио нэвтрүүлэх төв; • Нисэх буудлын ашиглалттай холбоотой техник тоног төхөөрөмжтэй барилгууд <ul style="list-style-type: none"> - Хяналтын цамхгийн цахилгааны дэд өртөө; - Курсын радио маякын цахилгааны дэд өртөө; - Глиссадын радио маякын цахилгааны дэд өртөө; - Гүний худгийн насосын байгууламж; - Хог хаягдал шатаах зуухны байгууламж; • Үйлчилгээний зориулалт бүхий туслах барилгууд <ul style="list-style-type: none"> - Харуул хамгаалалтын байр; - Хураамжийн цэг;
12.2	Ерөнхий төлөвлөгөө, архитектур, орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах зориулалтаар нь нисэх буудлын нутаг дэвсгэрт байрлуулах; - Архитектур орон зайн төлөвлөлтийг тоног төхөөрөмж, технологийн үндсэн дээр төлөвлөх.
12.3	Барилга, байгууламжийн үндсэн бүтээц, материал	<ul style="list-style-type: none"> - Барилгын бүтээц болон материалыг тухайн барилгын зориулалт, галын аюулгүй байдлын шаардлага, Монгол орны цаг агаар, газарзүйн онцлогт тохируулан сонгох. - Монгол Улсын стандарт болон технологийн шаардлагад нийцэх орчин үеийн барилгын материал ашиглах.
12.4	Инженерийн шугам сүлжээ хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - Шаардлага бүхий барилгуудыг нисэх буудлын цогцолборын инженерийн шугам сүлжээнд холбох, бие даасан байдлаар шийдвэрлэх
12.5	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм нормын дагуу галын аюул болон гал тэсвэрлэлтийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр барилгын материал, бүтээц, төлөвлөлт, гал унтраах тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.

---oOo---



БАТЛАВ
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
 ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
 УДИРДЛАГЫН ГАЗРЫН
 ДАРГА Ц.ОДХҮҮ

"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫГ ДАГАСАН ШИНЭ НИСЭХ БУУДЛЫН 4Е ХЯНАЛТЫН КОДТОЙ
 АЭРОДРОМЫН ИЖ БҮРЭН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 -р сарын 01 -ны өдөр

Дугаар: 12

№	Агуулга	Тайлбар
1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг "Хархорум хотыг сэргээн байгуулах тухай"; - Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол "Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай"; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" батлах тухай; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлах тухай; - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоол, "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо байгуулах тухай; - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 21 дүгээр тогтоол, "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай"; - Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хорооны даргын баталсан "Шинэ Хархорум" хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2025); - Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаал.
2	Захиалагч	<ul style="list-style-type: none"> - Зам, тээврийн хөгжлийн яам; - Иргэний нисэхийн ерөнхий газар.
3	Төслийн байршил	- Архангай аймаг, Өгийнуур сум.

Бүртгэлийн дугаар 213
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон хяналтын газрын үсэг
 2024 оны 05 сарын 01-ний өдөр

4	Зургийн ажлыг гүйцэтгэх Зөвлөх	- Аэродромын ерөнхий төлөвлөгөө, аэродромын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага, Аэродромын зураг төсөл боловсруулж байсан арвин туршлагатай байх.
5	Зураг төслийн үе шат, хугацаа	- 1 үе шаттай ажлын 3 хувь иж бүрэн зураг төсөв, 2024 он
6	Аэродромын хяналтын код	- 4E /Боинг 747-400, Боинг 787, Аэробус-340/
Нэг. Аэродром		
1.1	Зураг төслийн ажлын иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий төлөвлөгөө боловсруулах M1:2000; - Байршлын план, Саадыг хязгаарлах гадаргуу; - Босоо төлөвлөлтийн план зураг; - Хөөрч буух зурвасын ажлын зураг /дагуу ба хөндлөн огтлолууд/; - Явгалах замын ажлын зураг /дагуу ба хөндлөн огтлолууд/; - Перрон, агаарын хөлгийн зогсоолын ажлын зураг /дагуу ба хөндлөн огтлолууд/; - Тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолын ажлын зураг /дагуу ба хөндлөн огтлолууд/; - Периметрийн замын ажлын зураг /дагуу ба хөндлөн огтлолууд/; - Үерийн хамгаалалтын суваг, инженерингийн ажлын зураг; - Хашаа хамгаалалт, хаалга, гарцын ажлын зураг; - Аэродромын тэмдэгт, тэмдэглэгээний ажлын зураг; - Аэродромын элементүүдийн хийцлэлийн зураг; - Бусад элементүүдийн ажлын зураг; - Хучилтын тооцоо, даацын мэдээлэл /PCN, PCR/ хучилтын хийцийн зураг; - Навигацийн тоноглол, гэрэл суултын системийн суурилуулалтын төлөвлөлт болон ажлын зураг төсөл; - Газар шорооны ажлын картограм; - Барилгын ажлыг гүйцэтгэх зохион байгуулалтын төсөл; - Барилгын ажил гүйцэтгэх технологи, материалын техникийн шаардлага; - Шаардлагатай материалын тооцоо, судалгаа, нөөцийн байршил; - Инженер-геологийн хайгуул, зураглалын ажлын тайлан; - Инженер-геодезийн цэг, тэмдэгт, хайгуулын ажлын тайлан; - Инженер-геологийн судалгаа; - Аэродром, навигацийн барилга угсралтын ажлын хяналтын төсөв. - Тайлбар бичиг, төслийн танилцуулга;
1.2	Төлөвлөлтийн норм, шаардлагууд	<ul style="list-style-type: none"> - Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131, А/132 дугаар тушаалаар батлагдсан "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт" болон "Аэродром, аэродромын байгууламжийн барилгын ажилд тавигдах техникийн шаардлага" техникийн баримт бичгүүд; - Олон Улсын Иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын хавсралт 14 "Аэродромын төлөвлөлт, ашиглалт"; - Иргэний нисэхийн дүрэм 139; - Док 9184-ийн 1, 2, 3 дугаар дэвтэр; - Док 9157-ын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар дэвтэр; - Док 9137-ын 1, 2, 5, 6,7 дугаар дэвтэр; - Advisory circular a/c 150/5320-6D airport pavement design and Evaluation FAA;



		<ul style="list-style-type: none"> - Аэродромын элементүүд /Хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, перрон талбай, тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоол г.м/-ын зааварлах болон мэдээлэх тэмдэг, будган тэмдэглэгээний зургийг гаргах, аэродромын тэмдэгтүүдийн тавигдах шаардлагын дагуу тодорхойлно. - Хурдны явгалах зам төлөвлөх; - Хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам болон перрон талбайн хөндлөн ба дагуу налуугийн зохион байгуулалт нь аэродромын элементүүдээс ус зайлуулах нөхцөл хангагдсан байхаар, аэродромын стандартын дагуу төлөвлөх; - Перроны явгалах замын өргөн нь 23 метр байна; - Перрон талбайн хамгийн их налуу 1%-иас ихгүй байх; - Аэродромын элементүүд /Хөөрч буух хучилттай зурвас, явгалах зам, перрон талбайн хөвөө 2 тал тус бүрд 7.5 метрээс багагүй байхаар төлөвлөх; - Агаарын хөлөг болон бусад объект хоорондын зай 7.5 метрээс багагүй аюулгүйн зайчлалыг хангасан байх; - Перрон талбайн өргөтгөлийн хэмжээг тогтооходоо Боинг 747-400, Боинг 787, А340 маягийн агаарын хөлөгт зориулан төлөвлөх; - Аэродромын байршлыг ИНЕГ-аас томилсон ажлын хэсгийн тайланд үндэслэх.
1.5	Аэродромын элементүүдийн бүтэц	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын байгаль цаг агаарын /зам барилгын бүс/ эрс тус уур амьсгалын нөхцөлийг тооцох, хучилтын насжилтийг үндэслэлтэй тооцож гаргах.
1.6	Инженерийн эрэл хайгуулын ажилд тавих шаардлага	<ul style="list-style-type: none"> • Инженер-геологийн хайгуулын ажлыг гүйцэтгэж, шаардлагатай хэсгүүдэд нэмэлт ажил гүйцэтгэнэ. Эдгээр эрэл хайгуулын ажлын хэмжээ нь ажлын зураг төслийн шаардлагад бүрэн нийцэж байх, • Инженерийн хайгуулын ажлыг эхлэхээс өмнө техникийн даалгаврыг боловсруулж, захиалагч талтай зөвшөөрөлцсөн байна, • Инженерийн хайгуулын ажлын материал нь хүрээлэн буй орчин, газар нутгийн талаар дүгнэлт гаргахад хангалттай хэмжээнд хийгдсэн байна, • Эдгээр иж бүрдэл ажлуудыг БНБД-ийн шаардлагуудад нийцүүлсэн байх, • Инженер-геологийн хайгуулын явцад геологийн төвөгтэй нөхцөл, хөрсний ус зэрэг илэрвэл түүнд тохирсон инженерийн шийдлүүдийг нарийн тусгаж оруулна, • Аэродромын барилга угсралтын ажилд ашиглах эрдэс, материалын ордуудын байрлалыг тодорхойлсон байна.
1.7	Төслийн баримт бичиг	<p>Батлагдсан (зураг төсөл, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (5 хувь флаш-нд бичиж) бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг хүлээлгэж өгнө.</p> <ul style="list-style-type: none"> • Тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls, AutoCAD өргөтгөлөөр, байр зүйд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгнө.



Танилцсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны
Иргэний нисэхийн бодлого
зохицуулалтын газрын ахлах
мэргэжилтэн

Иргэний нисэхийн ерөнхий газрын
дарга

Хянасан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
Төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн

Боловсруулсан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
нисэх буудлын бодлогын хэрэгжилт
хариуцсан мэргэжилтэн

Г.Лувсан-Одсэр

Ч.Мөнхтуяа

Ч.Одгэрэл

Б.Энх-Амгалан

Э.Мөнх-Эрдэнэ



2024 оны ...-р сарын ...-ны өдрийн
 дугаартай зургийн
 даалгавар Хавсралт-1

"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫГ ДАГАСАН ШИНЭ НИСЭХ БУУДЛЫН 4Э ХЯНАЛТЫН ХОДТОН
 АЭРОДРОМЫН ИЖ БҮРЭН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

д/д	Тайлбар	Ерөнхий шаардлага
1. Хөөрч буух хучилттай зурвас		
1.1	Дагуу налуу	<ul style="list-style-type: none"> - Тэнхлэгийн хамгийн их өндөржилт хамгийн бага өндөржилт хоорондын ялгаврыг нийт уртад харьцуулсан налуу 1%-иас хэтрэхгүй байх ёстой. - Уртын эхний болон сүүлчийн хэсгийн (1/4) дагуу налуу 0.8%-иас хэтрэхгүй байх ба бусад тохиолдолд 1.25%-иас хэтрэхгүй байх. - Нэг налууугаас нөгөө налуу руу шилжсэн шилжилтийн хазайлтын радиусын доод хэмжээ 30 метр тутамд 0.1% гадаргуугийн налуу дагуу явагдах ёстой. - 3 метрийн өндөрт байрласан аливаа цэгээс мөн тухайн төвшинд орших бусад бүх цэгүүд хөөрч буух зурвасын уртын хагастай тэнцэх зайнаас үзэгдэх ёстой.
1.2	Хөндлөн налуу	<ul style="list-style-type: none"> - Хөөрч буух зурвасаас ус аль болох түргэн урсаж зайлах ёстой. - Налуу нь 1.5%-иас хэтрэхгүй байх. - Өргөн нь хоёр захын хөвөөний хамтаар 60 метрээс багагүй өргөнтэй байх.
1.3	Хөвөө	<ul style="list-style-type: none"> - Хөөрч буух зурвасын гадаргуутай нэг ижил төвшинд байх бөгөөд хөндлөн налуу нь 2.5%-иас ихгүй байх. - Хөвөөний өргөн 7.5 м
2. Явгалах зам		
2.1	Геометрийн хэмжээснүүд	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн үндсэн тулгуур дугуй хоорондын зай нь 18 метр буюу түүнээс дээш бол явгалах замын төгсгөлийн ирмэгээс 4.5 метрээс багагүй зайтай байх. - Аэродромын явгалах замын даац авах хэсгийн өргөн нь 23 м, хөвөө 7,5 м-ээс багагүй байна.
2.2	Налуу	<ul style="list-style-type: none"> - Дагуу болон хөндлөн налуу 1.5%-иас ихгүй байх. - Дагуу босоо муруйн радиус 3000 м-ээс багагүй байх. - 3 метрийн өндөрт байрлах аливаа цэгээс 300 метр хүртэл орших зайд харагдах ёстой.
3. Перрон талбай, агаарын хөлгийн зогсоол		
3.1	Перроны хэмжээ	- Перроны нийт талбай нь тооцоот хамгийн их хөдөлгөөний эрчим дэх аэродромын нэвтрүүлэх чадварыг хангахад хүрэлцээтэй байна.
3.2	Налуу	- Хамгийн их налуу 1%-иас ихгүй байх.
3.3	Зогсоол	- Агаарын хөлөг болон бусад объект хоорондын зай 7.5 метрээс багагүй аюулгүйн зайчлалыг хангасан байх.
4. Тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоол		
4.1	Зай хэмжээс	- Дээрх тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолын байршлыг бусад зогсоол, барилга, олон нийтийн газраас аль болох хол зайтай, ямар ч тохиолдолд тэдгээрээс 100 метрээс багагүй зайд тогтооно.
4.2	Зогсоолын шаардлага	- Зогсоолыг хийн агуулах, ШТС, цахилгаан болон холбооны кабель шугам бүхий газар доорх инженерингийн байгууламж дээр байрлуулж болохгүй.
5. Төгсгөлийн аюулгүйн зурвас		

Бүртгэлийн дугаар ... 213 ...
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛБАР ҮНЭН
 Хуульбар олгосон ажиртны гарын үсэг
 2024 оны 05 сарын 08 өдөр

5.1	Зай хэмжээс	<ul style="list-style-type: none"> - Хөөрч буух зурвасын төгсгөл хэсэгтэй залгаа байрлах ба 240 метр багагүй урттай байх. - Хөөрч буух зурвасын өргөнөөс 2 дахин их байх.
6. Тоормозлох зурвас		
6.1	Тоормозлох зурвасын урт	- Урт нь 60 метр, өргөн нь нислэгийн зурвасын өргөнтэй ижил байх ба залгуулан хийх.
6.2	Дагуу болон хөндлөн налуу	- Дагуу налуу 1.5% хөндлөнгийн налуу нь 2.5%-иас ихгүй байх.
7. Нислэгийн зурвас		
7.1	Ерөнхий зүйл	- Нислэгийн зурвас нь ХБЗ болон түүнтэй залгаа тоормозлох зурвасыг багтаана.
7.2	Нислэгийн зурвасын урт	- Нислэгийн зурвас нь ХБЗ болон ТЗ-ын эхлэл хүртлэх болон төгсгөлөөс цааш 60 метрээс доошгүй урттай байх ёстой
7.3	Нислэгийн зурвасын өргөн	- Нарийвчлалтай ойртолт үйлдэхээр тоноглогдсон ХБЗ-ын хувьд нислэгийн зурвас нь ХБЗ-ын тэнхлэгээс хөндлөн чиглэлд 140 метрээс багагүй байна.
8. Ус зайлуулах систем		
8.1	Төлөвлөлтийн норм, шаардлагууд	<ul style="list-style-type: none"> - "Нисэх буудлын хаягдал ус зайлуулах систем" (A/C 150/5320-5), 1983, (FAA) - Олон улсын иргэний нисэхийн байгууллагын эко нисэх буудал болон Олон улсын нисэх буудлуудын холбооны гаргасан "Нисэх буудлын хаягдал ус зайлуулах байгууламжийн төлөвлөлтийн гарын авлага, газар доорх зам болон нэгдсэн байгууламж" заавар зөвлөмжийн ашиглах.
8.2	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Засвар үйлчилгээ хийхэд хялбар байх болон барилгын ажлын өртгийг хямдруулах талаас тооцон, ус зайлуулах байгууламжийг зурвастай огтлолцлыг бууруулахад анхаарах. - Голын урсцын нөлөөллийг бууруулах болон голын доод хэсэгт үүсэх усны илүүдэл үүсгэхгүйн тулд ус зайлуулах систем тус бүрийн гадагшлуулах, урсгал дээр тохиргооны цөөрөм байгуулахаар төлөвлөх.
9. Аэродромын үйлчилгээний зам		
9.1	Перрон дээрх хөдөлгөөний эрчим, ачаалал	<ul style="list-style-type: none"> - Агаарын хөлгийн чирэгч болон бусад газрын үйлчилгээний тусгай тоноглолтой машинууд, - Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс машин механизмын маршрутыг төлөвлөх. - Гал унтраах, авран хамгаалах зориулалтын машинууд, хөдөлгөөний эрчим 20 жилээр
10. Инженерийн эрэл хайгуулын ажлын хэмжээ, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага		
10.1	Ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none"> - Инженер-геологи-гедрогеологийн хайгуулын ажлыг гүйцэтгэж, шаардлагатай хэсгүүдэд нэмэлт ажил гүйцэтгэнэ. Эдгээр эрэл хайгуулын ажлын хэмжээ нь ажлын зураг төсөлд ашиглах шаардлагад бүрэн нийцэх байх шаардлагатай. - Инженер-геологи-гедрогеологийн ажлыг "Хэмжлийн нэгдмэл байдлын тухай болон Геодезийн зураг зүйн тухай" хуулийн дагуу гүйцэтгэнэ. - Инженерийн хайгуулын ажлыг эхлэхээс өмнө техникийн даалгаврыг боловсруулж захиалагч талтай зөвшөөрөлцсөн байна.



	<ul style="list-style-type: none">- Инженерийн хайгуулын ажлын материал нь хүрээлэн буй орчин, газар нутгийн талаар дүгнэлт гаргахад хангалттай хэмжээнд хийгдсэн байна.- Эдгээр иж бүрдэл ажлуудыг БНБД-ийн шаардлагуудад нийцүүлж хийх,- Инженер-геологи-гедроггеологийн хайгуулын явцад геологийн төвөгтэй нөхцөл, хөрсний ус зэрэг илэрвэл түүнд тохирсон инженерийн шийдлүүдийг нарийн тусгаж оруулна.- Аэродромын барилга угсралтын ажилд ашиглах эрдэс, материалын ордуудын байрлалыг тодорхойлсон байна.
--	---

---oOo---



БАТЛАВ
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
 ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
 БИЧИГ ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОНГУЙЦЭТГЭГЧ
 БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
 УДИРДЛАГЫН ГАВЬЫН
 ДАРГА Ц.ОДХҮҮ

**"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫГ ДАГАСАН ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН
 БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН 4Е ХЯНАЛТЫН КОДТОЙ АЭРОДРОМ,
 ЗОРЧИГЧ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БҮХИЙ ШИНЭ НИСЭХ БУУДАЛ БАЙГУУЛАХ
 ТӨСЛИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
 ДААЛГАВАР**

2024 оны 05 -р сарын 01 -ны өдөр

Дугаар: 10

№	Агуулга	Тайлбар
1	Судалгааны нэр	- "Шинэ Хархорум" хотыг дагасан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4Е хяналтын кодтой аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий шинэ нисэх буудал байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгавар.
2	Судалгааг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг "Хархорум хотыг сэргээн байгуулах тухай"; - Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол "Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай"; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" батлах тухай; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлах тухай; - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоол, "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо байгуулах тухай; - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 21 дүгээр тогтоол, "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай"; - Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хорооны даргын баталсан "Шинэ Хархорум" хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2025); - Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаал.

Бүртгэлийн дугаар ...215...
 МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ХУУЛБАР ҮНЭН
 Хуулиар өргөсөн ажилтны гарын үсэг
 2024 оны 05 сарын 01-ны өдөр

3	Судалгааны байршил	<p>- Архангай аймаг, Өгийнуур сум.</p> <p>- Товч мэдээлэл Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Монгол улсын нутаг дэвсгэрийн төв цэгээс 100 км-ийн зайд оршдог бөгөөд далайн түвшнээс дээш дунджаар 1350-2300 метрийн өндөрт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өгийнуур сумдын хил дамнан ойролцоогоор 200 мян.га талбайг хамарсан Орхон гол дагуу урдаасаа хойш босоо чиглэлд сунан байршиж тус нутаг дэвсгэрийн 10 хувийг эзэлдэг.</p> <p>Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь Орхоны хөндийд байрлаж байсан нь археологийн судалгаагаар нотлогдсон бөгөөд Орхоны хөндий нь физик газарзүйн болон түүх, соёлын дурсгал археологийн хувьд судалгааны онцгой ач холбогдолтой газар нутаг бөгөөд Монгол улсаас анх удаа соёлын ангиллаар 2004 онд Орхоны хөндийн 121967.7 га газрыг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтын 1081-д бүртгүүлж ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд "Соёлын дурсгалт газар"-аар бүртгэгдсэн.</p> <p>"Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл"-ийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Орхоны хөндийд "Шинэ Хархорум" хот байгуулах зориулалтаар Архангай аймгийн Өгийнуур, Хашаат сум болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт нийт 189363,19 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан.</p>
4	Захиалагч	<p>- Зам, тээврийн хөгжлийн яам; - Иргэний нисэхийн ерөнхий газар.</p>
5	Гүйцэтгэгч байгууллага	<p>- Зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй, гадаадын болон дотоодын байгууллага. Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байсан арвин туршлагатай байх.</p>
6	Судалгааг хэрэгжүүлэх хугацаа	<p>- Судалгааны ажлыг гэрээ байгуулснаас хойш 3 сарын дотор хийж гүйцэтгэх.</p>
7	Төслийн цар хүрээ	<p>- Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахтай холбоотойгоор дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>- <u>Зах зээлийн судалгаа боловсруулах:</u></p> <ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн макро орчны судалгаа; • "Шинэ Хархорум" хотын хүм ам, суурьшлын бүсийн судалгаа; • Нисэх буудлыг Олон улсын статустай болгох, түүний үр өгөөжийн судалгаа; • Монгол Улсын аялал жуулчлалын судалгаа, Хангайн бүсийн хүн ам, агаарын тээврийн эрэлт хэрэгцээний судалгаа; • Агаарын тээврийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон дунд, урт хугацааны зорчигчдын ачаалал, ачаа урсгалын эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын талаарх судалгаа; • Тус нисэх буудлын гол харилцагч талуудын талаар судалгаа; • Олон улсын агаарын зам, түүний уялдуулан хөгжүүлэх судалгаа; • Аэродром, нисэх буудал, навигацийн үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох. • Ачаа, шуудан, тээврийн хэтийн төлөв, эрэлт хэрэгцээ, түүнтэй уялдуулан хөгжүүлэх судалгаа. • Нисэх буудал дагасан аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байр нэмэгдүүлэх судалгаа;



- Техникийн магадлалын судалгаа боловсруулах:

- Нисэх буудал /Зорчигч үйлчилгээний цогцолбор, аэродром, навигаци г.м/-ын ерөнхий төлөвлөгөө, хүчин чадал, ерөнхий үзүүлэлт;
- Төслийн талбайн газар зүйн солбицол бүхий зураг, геологийн тогтцын судалгаа, газар хөдлөл, чичирхийллийн судалгаа, ус зүй, цаг уурын төлөв байдлын судалгаа зэрэг;
- Нисэх буудлын хүний нөөцийн талаарх судалгаа;
- Нисэх буудлын нийт барилга байгууламжийн хүчин чадлын талаарх судалгаа;
- Технологийн схем, технологийн холбоос зураг, нисэх буудлын үйлчилгээний процесс бүрийн технологийн схем зэрэг;
- Шаардлагатай тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоо ширхгийн талаар судалгаа;
- Нисэх буудлын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой байгууллагын бүтэц, орон тоо, ажиллах хүчинд тавигдах шаардлагын талаар судалгаа;
- Нисэх буудлын орчимд баригдах барилга байгууламжийн өндрийн саад болон газар ашиглалтыг "Шинэ Хархорум" хотын төлөвлөлттэй нийцүүлсэн судалгаа. Саадыг хязгаарлах гадаргуу болон аэродром орчмын аюулгүйн бүсийн шаардлагыг баримтлах;
- Зам, тээврийн сүлжээ нь "Шинэ Хархорум" хоттой тогтвортой тээврээр сүлжээгээр холбох шийдлийг тодорхойлох;
- Ачаа, тээврийг зохицуулах үйлчилгээ бүхий тээвэр, логистикийн зангилааны боломжит байршлыг тодорхойлох;
- Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчид тавигдах шаардлага болон барилгын ажлын ерөнхий төлөвлөгөө.

- Санхүүгийн төсөөлөл, үр ашгийн тооцооллын судалгаа боловсруулах:

- Шинэ нисэх буудал байгуулахтай холбоотойгоор шаардагдах нийт санхүүжилт, түүний зарцуулалтын задаргаа;
- Капиталын оновчтой бүтцийг хэрхэн бүрдүүлэх талаар судалгаа;
- Үйлчилгээний үнэ, тариф, борлуулалтын төсөөллийн талаар судалгаа;
Нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотойгоор гарах зардлын судалгаа;
- Санхүүжилтийн зардлын судалгаа;
- Санхүүгийн загвар;
- Ирээдүйн капиталын хэрэгцээг тодорхойлох;
- Санхүүгийн үр дүнгийн ерөнхий үзүүлэлтүүд /NPV, IRR, хөрөнгө оруулалт нөхөх хугацаа, ашгийн түвшин гэх мэт/;
- Мэдрэмжийн шинжилгээ.

- Нийгэм-эдийн засаг, байгаль орчны судалгаа боловсруулах:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэх;
- Инженер-геологи болон гидрогеологийн судалгаа;
- Археологийн хайгуулын судалгаа;
- Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ;
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудлаар менежмент.
- Хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох;

- "Шинэ Хархорум" хотын төлөвлөлттэй үялдах байдал:



		<ul style="list-style-type: none"> • Нисэх буудлын барилга байгууламж, дэд бүтцийг "Шинэ Хархорум" хотын төлөвлөлттэй уялдуулах талаарх судалгаа.
8	Судалгааны ажлын хамрах хүрээ, гарах үр дүн	<ul style="list-style-type: none"> - "Шинэ Хархорум" хотыг дагасан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4E хяналтын кодтой аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий шинэ нисэх буудал байгуулах төслийн ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЙЛАН. - Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэх баг дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Багийн ахлагч: Агаарын тээврийн эдийн засагч: Судалгааны ажлыг хэрэгжүүлэх гэрээ баталгаажсан үеэс эхлэн хэрэгжилтийг зохион байгуулж, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хэмжээнд чанартай гүйцэтгэх, зөвлөхүүдийн хийх ажилд хяналт тавих, хийх ажлыг төлөвлөх, тайлан гаргахад хяналт тавьж, холбогдох байгууллагуудаас санал авах, санал зөвлөмжийг тайланд тусгах ажлуудыг зохион байгуулан, ажлыг гэрээнд заасны дагуу хугацаанд нь гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. Бодлогын хувилбарын уялдааг хангана. Мөн тайлангийн явц, эцсийн тайлангийн талаар хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулна. Агаарын тээврийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, магистр болон түүнээс дээш зэрэгтэй бөгөөд салбартаа 5-аас доошгүй жил ажилласан байх. • Аэродром хариуцсан зөвлөх: Аэродромын хийц, зураг төсөлд стандартын шаардлагын дагуу үнэлэлт дүгнэлт, аюулгүйн ажиллагааны эрсдэлийн менежмент, аэродромын ерөнхий төлөвлөгөө, санал, зөвлөмж боловсруулна. Зөвлөх нь иргэний нисэхийн салбарт аэродромын инженер, мэргэжилтнээр ажиллаж байсан, салбартаа 5-аас доошгүй жил ажилласан байх. • Нислэг хөдөлгөөний менежмент хариуцсан мэргэжилтэн: Иргэний нисэхэд нислэгийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд нислэгийн менежментийн санал зөвлөмж боловсруулна. Мэргэжлээрээ бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байна. • Агаарын навигацийн мэргэжилтэн: Иргэний нисэхэд агаарын навигацийн чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд шинэ нисэх буудалд ашиглах навигацийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүн байна. • Хууль эрх зүйн зөвлөх: Хууль эрх зүйн зөвлөмж гүйцэтгэх чадвартай байх бөгөөд судалгааны явцад болон төслийн хэрэгжилтэд хууль эрх зүйн талаас тулгарах асуудлуудыг дэвшүүлэн, зөвлөмж боловсруулна. Олон улсын болон Монгол Улсын эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүн байна. • Архитектур: Нисэх буудлын барилгын зураг, төсвийг боловсруулах үүрэг бүхий архитектурын чиглэлээр магистр болон түүнээс дээш, Монгол Улсын мэргэшсэн зэрэгтэй хүн байна. • Барилгын инженер: Барилгын зураг, төсвийг боловсруулах үүрэг бүхий барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш, Монгол Улсын мэргэшсэн зэрэгтэй хүн байна. • Байгаль орчин, нийгэм эдийн засгийн хариуцсан мэргэжилтэн: Байгаль орчны менежмент, нийгэм эдийн засгийн чиглэлээр
9	Судалгааны багт тавигдах шаардлага	



		<p>мэргэшсэн 10-аас доошгүй жил ажилласан дадлага, туршлагатай хүн байна.</p> <ul style="list-style-type: none"> • <u>Туслах ажилтан</u> (1 хүн): Судалгааны ажлын хэрэгжилтийн хугацаанд ажиллан, зөвлөхүүдийн зааврын дагуу компьютерт судалгааны дүнг нэгтгэх, хэвлэх, олшруулах ажлуудыг гүйцэтгэнэ.
10	Судалгааны тайлангийн үе шат	<ul style="list-style-type: none"> - <u>Явцын тайлан</u>: Судалгааны ажлын явцын дэлгэрэнгүй тайланг Захиалагч талд сар бүрийн 10-ны өдрийн дотор хүргүүлэх. - <u>Эцсийн тайлан</u>: Дээр дурдсан судалгааны ажлуудыг нэгтгэсэн ТЭЗҮ-ийн тайлан болон бусад холбогдох зураг, төсөв, үнэлгээний тайлангуудыг монгол/англи хэл дээр тус бүр хэвлэмэл болон файл хэлбэрээр захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг (Soft хэлбэрээр 5 хувь) хүлээлгэж өгнө. Мөн тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls өргөтгөлөөр, байр зүйн зураглалд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгнө.

Танилцсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны
Иргэний нисэхийн бодлого
зохицуулалтын газрын ахлах
мэргэжилтэн



Г.Лувсан-Одсэр

Иргэний нисэхийн ерөнхий газрын
дарга



Ч.Мөнхтуяа

Хянасан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга



Ч.Одгэрэл

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн



Б.Энх-Амгалан

Боловсруулсан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
нисэх буудлын бодлогын хэрэгжилт
хариуцсан мэргэжилтэн



Э.Мөнх-Эрдэнэ

